

## МОНГОЛ УЛСЫН ТӨСВИЙН ТӨЛӨВЛӨЛТ, 2023 ОНЫ ТӨСВИЙН АСУУДЛААР УЛСЫН ИХ ХУРАЛ, ЗАСГИЙН ГАЗАРТ ХҮРГҮҮЛЖ БУЙ ДҮГНЭЛТ, САНАЛ, ЗӨВЛӨМЖ

2022.10.20

Нээлттэй Нийгэм Форумын дэргэдэх Төсвийн зөвлөл нь “Монгол Улсын 2023 оны төсвийн төлөвлөлт” сэдвээр хэлэлцүүлэг хийж, Улсын Их Хурал, Засгийн газарт хандан төсвийн төлөвлөлтийн асуудлаар дараах дүгнэлт, санал, зөвлөмжийг толилуулж байна. Үүнд:

### **1. Монгол Улсын 2023 оны төсвийн төслийг боловсруулахдаа үндэслэсэн макро эдийн засгийн төсөөлөл нь гадаад эдийн засгийн орчинтой нийцээгүй, хэт өөдрөг болсон байна.**

Макро эдийн засгийн тооцооллыг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авахыг санал болгож байна. Үүнд:

- Гадаад улс төр, эдийн засгийн орчны судалгааг сайн хийх;
- Эдийн засгийн төлөв байдлын хувилбартай таамаглал, тооцоолол хийх (өөрөөр хэлбэл, нүүрс 36.5 сая тонныг экспортолж чадахгүй бол орлого хэрхэх вэ гэдгийг танилцуулах);
- Макро эдийн засгийн төсөөлөл хийхдээ бие даасан судалгааны байгууллагатай хамтран ажилладаг байх.

### **2. 2023 оны төсвийн орлого төлөвлөлт бодитой бус байна.** Нүүрсний экспортыг хэт өөдрөг тооцоолжээ. Тавантолгой-Гашуунсухайтын төмөр зам бүрэн ашиглалтад ороогүй тул 36.0 сая тонн нүүрс экспортлох төсөөлөл бодитой байж чадахгүй юм.

Төсвийн орлого төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авахыг санал болгож байна. Үүнд:

- Төсвийн тэнцлийг нааштай харагдуулах үүднээс төсвийн хэт өндөр зарлагыг төсөвт багтаах зорилгоор төсвийн орлогыг үндэслэлгүйгээр хэт хөөсрүүлэн төлөвлөж байгааг зогсоох хэрэгтэй байна. Үүний тулд төсвийн орлогыг бие даасан институци, судалгааны хүрээлэн төлөвлөдөг болох нь зүйтэй байна.
- Хувилбартай орлогын төсөөлөл танилцуулах.

### **3. 2023 оны төсвийн урсгал зарлагын төлөвлөлтийг сайжруулах нь зүйтэй байна.** Манай улсын эдийн засагт бүтцийн гажуудал маш ихтэй. Түүхий эдийн үнийн өсөлтөд найдсан, түүнд тулгуурласан маш үрэлгэн бүтцийг санхүүжүүлсээр, үүний улмаас төсвийн зарлага хэт тэлж, төсвийн алдагдал нэмэгдэн, гадаад өрийн хэмжээ асар их хэмжээнд хүрч, эдийн засагт дарамт үүсгэж байна. Хэмнэлт, нөгөө талаас эдийн засгийг дэмжих халамжийн бодлого гэж байгаа нь хоорондоо уялдахгүй байна. Урсгал зардлын хэмнэлт нь үндсэн үйл ажиллагааг хэвийн явуулахад саад учруулах магадлалтай юм.

Төсвийн урсгал зарлагын төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг авахыг санал болгож байна. Үүнд:

- Төсвөөс санхүүжүүлэх шаардлагагүй, үр ашиггүй барилга байгууламж, үйл ажиллагааг төсвөөс санхүүжүүлж байгаа явдлыг халах;
- Төрөөс ямар үйлчилгээг иргэдэд, ямар арга замаар хүргэх вэ гэсэн бодлогыг бүхэлд нь дахин авч үзэж, өөрчлөх хэрэгтэй. Үүний дараа төсвийн зарлагыг оновчтой төлөвлөх суурь нөхцөл бүрдэнэ. Жишээлбэл, хөдөөд Соёлын төвийн үйл ажиллагааг ерөнхий боловсролын сургуулийн спорт заалтай нэг дор хамтдаа байхаар төлөвлөж, үйл ажиллагааг санхүүжүүлэх бүрэн боломжтой.

**4. 2023 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг оновчтой болгох шаардлагатай байна.** Ирэх оны тухайд шинээр хөрөнгө оруулалтын төслийг эхлүүлэхгүй гэдэг нь зөв шийдвэр. Гэвч өнгөрсөн жилүүдэд хөрөнгө оруулалтын объектыг сонгохдоо улс төрийн ач холбогдол, сонгуулийн тойргийг харж сонголт хийснээс бус нийгэм, эдийн засгийн үр ашгийг зөв тооцоолж байгаагүй нь хөрөнгө оруулалтын бодлогыг томоохон алдаанд хүргэсэн.

Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг сайжруулах чиглэлээр дараах арга хэмжээг санал болгож байна. Үүнд:

- Аль салбарт, ямар үйл ажиллагааг төр цаашид санхүүжүүлэхгүй вэ гэдгийг шийдэх;
- Улсын төсвийн хөрөнгө оруулалтаар баригдсан барилга, объектуудын эдийн засгийн үр ашиг, ашиглалтын байдлыг эргэн дүгнэж үзэх;
- Чанар муутай барилга, объект барьж, хүлээн авч байгаагийн улмаас улсын төсвийн хөрөнгийг дахин дахин зарцуулах, үр ашиггүй зарцуулах нэг нөхцөл болж байна. Иймд чанар, стандартыг цоо шинээр мөрдүүлэх.

**5. Гадаад зээл, тусламжийн төлөвлөлтийг сайжруулах хэрэгтэй байна.** Үүний тулд Засгийн газар зорилгодоо нийцсэн хөтөлбөрт суурилсан төсөвлөлтийг хийж, зардлын эх үүсвэрүүдийг тодорхой, урт хугацаагаар төлөвлөх нь зүйтэй байна.

**6. 2023 оны төсвийн алдагдлыг бууруулах шаардлагатай байна.** Монгол Улсын хувьд төсвийн алдагдлыг эцсийн дүндээ гадаад өрөөр л санхүүжүүлэхээс өөр сонголтгүй байна. Иймд дараах арга хэмжээг санал болгож байна. Үүнд:

- Дунд ба урт хугацаанд төсвийн төлөвлөлтийг сайжруулах, эдийн засаг дахь төрийн оролцоог бууруулах, макро эдийн засгийн оновчтой бодлого баримтлах замаар төсвийн алдагдлыг жил тутамд 2 хувиас бага байлгах;
- Нэгэнт хуримтлагдсан гадаад өр төлбөрийг тууштай бууруулах зорилгоор зөвхөн ашигтай төсөв батлах бодлого баримтлах ёстой. Иймээс ирэх жилүүдэд төсвийн зарлага ба төсвийн алдагдлыг нэмэгдүүлэхгүй байх, бууруулах бодлогыг баримтлах хэрэгтэй байна.
- Төсвийн зардлаа эрэмбэлэх.

**7. Улсын төсвийг Засгийн газар хэлэлцэхэд тавигдах шаардлагыг хуульд тусгах нь зүйтэй байна.** Төсвийн төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байгаа нь харагдаж байгаа тул Сангийн яамнаас өргөн барьж буй ирэх оны улсын төсвийг Засгийн газар нухацтай хэлэлцэж байх нь чухал юм. Иймд төсвийг Засгийн газар хэлэлцэхэд тавигдах шаардлагыг Төсвийн тухай хуульд тусгах хэрэгтэй байна.

**8. Татварын хуулиудыг ирэх оны төсвийн тухай хуулиас тусад нь хэлэлцдэг байх нь зүйтэй байна.** Татварын хуулийн өөрчлөлт нь иргэн, аж ахуйн нэгжийн орлого, үйл ажиллагаанд нөлөөлөл үзүүлэх тул нухацтай хэлэлцэн гаргах шийдвэр юм. Энэхүү чухал асуудлыг ирэх оны төсвийн тухай хуулийг хэлэлцэх нэг

сар гаруйн маш богино хугацаанд хэлэлцэн шийдвэрлэх нь учир дутагдалтай юм. Татварын хуульд өөрчлөлт оруулах эсэх асуудлыг нарийн судалгаа, тооцоолол хийж, олон нийтийн оролцоог хангасны үндсэн дээр шийдвэрлэх нь зүйтэй. Жишээлбэл, өсөн нэмэгдэх ХХОАТ-ыг авахдаа өрхийн ам бүлийн тоог харгалзан үзэх үү, зөвхөн цалингаас авах уу, бусад орлогоос мөн авах уу зэрэг олон хүчин зүйлийг харгалзан үзэх шаардлагатай байна.

**9. Ирээдүйн өв сангийн хуулийг ирэх оны төсвийн тухай хуулиас тусад нь хэлэлцэх нь зүйтэй байна.** Энэхүү чухал асуудлыг ирэх оны төсвийн тухай хуулийг хэлэлцэх нэг сар гаруйн маш богино хугацаанд хэлэлцэн шийдвэрлэх нь зохисгүй байна.

## НЭЭЛТТЭЙ НИЙГЭМ ФОРУМЫН ДЭРГЭДЭХ ТӨСВИЙН ЗӨВЛӨЛ